



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 03

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017.08.04-2017.08.06-ны хооронд тэмдэглэсэн сургуулийн ойгоор бусдаас 12,040,000 төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг хандивласан байхад түүнийг хөрөнгөнд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана" гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:


1. Бусдаас хандиваар ирсэн 12,040,000 төгрөгийн хөрөнгийг орлогоор бүртгэж, санхүүгийн тайланд тусгах

2517111

3. Албан шаардлагын биелэлтийг 2018.02.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэцогт сумын сургуулийн захирал Ш.Гэрэлмаа , нягтлан бодогч Ү.Банзрагч нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹:  Б.ДОЛЖМАА	
	ЗӨВШӨӨРСӨН:  Ш.ГЭРЭЛМАА	
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ	 Ү.БАНЗРАГЧ	НЯГТЛАН БОДОГЧ



¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 04

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Эрдэнэцогт сумын Соёлын төвийн 2017 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 2017 оны 08 дугаар сард ном хөтөлбөрийн санхүүжилтээр 1000,0 мянга, 09 дүгээр сард иргэдийн хандиваар 2799,0 мянган төгрөгийн орлого орж, үүнээс 09 дүгээр сард засварын зардалд 1050,0 мянга, ном худалдан авахад 1000,0 мянган төгрөг зарцуулж, 1749,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад нэмэлт санхүүжилтийн орлого, зарлага, үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй.

2. 2017 оны 03 дугаар сард н.Ганболдоос 20,0 мянган төгрөгийн өөрийн орлого тушаасан байхад түүнийг орлогоор бүртгээгүй.

3. Байгууллагын дансанд оны эхний авлагын 265,5 мянган төгрөгийг тушааж, авлагыг барагдуулсан байхад санхүүгийн тайланд авлагыг барагдуулалгүй, өөрийн орлогоор бүртгэсэн.

4. "Содсовин" ХХК-аас худалдан авсан 219,0 мянган төгрөгийн сандал, иргэн Ж.Ганболдоос худалдан авсан 250,0 мянган төгрөгийн ширээг аж ахуйн материалд бүртгэсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна.

2517114

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн санхүүжилт, зардал, харилцах дансны үлдэгдлийн 3799,0 мянга, өөрийн орлогын 20,0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаж, худалдан авсан номыг хөрөнгөд орлого авах
2. Өмнөх оны авлагын 265,5 мянган төгрөгийг барагдуулсан НББ-ийн бичилтийг үнэн зөв хийж, өөрийн орлогыг залруулж бүртгэх
3. Тайлант хугацаанд худалдан авч бараа материалд бүртгэсэн 469,0 мянган төгрөгийн ширээ,сандлыг үндсэн хөрөнгөд залруулж бүртгэх
4. Албан шаардлагын биелэлтийг 2018.02.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэцогт сумын Соёлын төвийн төсвийн захирагч Л.Ганчимэг , нягтлан бодогч Ү.Банзрагч нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹: 	Б.ДОЛЖМАА
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ	ЗӨВШӨӨРСӨН: 	Л.ГАНЧИМЭГ
НЯГТЛАН БОДОГЧ	 Ж0001	Ү.БАНЗРАГЧ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 05

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Өлзийт сумын ИТХ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 7000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 2333.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 2017 оны 03 дугаар сард 1200.0 мянган төгрөгөөр батерей сольсон Приус-10 маркын автомашиныг сумын хэсгийн төлөөлөгчөөр ажиллаж байсан Н.Лхагвадорж эзэмших хугацаандаа 2017 оны 11 сарын сүүлчээр унагаж эвдэлсэн байхад тооллогын бүртгэлээр хөрөнгийг бодитоор байгаагаар нь бүртгэсэн, 2017 оны 11-12 дугаар сард элэгдэл байгуулсан, асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

2517115

1. Хохирлын хэмжээг тогтоолгож, холбогдох байгууллагуудаар асуудлыг шийдвэрлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.04.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өлзийт сумын ИТХ-ын дарга С.Гонгор, нарийн бичгийн дарга Д.Нарантуяа, нягтлан бодогч Ч.Сүрэнлхам нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹: 	Б.ДОЛЖМАА
ДАРГА	ЗӨВШӨӨРСӨН:  ӨЛЗИЙТ СУМЫН ИТХ-ЫН	С.ГОНГОР
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА		Д.НАРАНТУЯА
НЯГТЛАН БОДОГЧ		Ч.СҮРЭНЛХАМ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.